



**ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН  
ХЯНАЛТЫН ТАЙЛАН 2016**

## АГУУЛГА

---

Товч хураангуй.....	1
1. Төлбөрийн системийн хяналтын талаарх олон улсын зарчмууд .....	2
Төлбөрийн систем гэж юу вэ? .....	2
Төлбөрийн системийн эрсдэл.....	2
Төлбөрийн системийн хяналт гэж юу вэ?.....	3
Төлбөрийн системийн хяналтын зарчмууд.....	3
2. Монголбанкнаас тавих хяналтын хамрах хүрээ .....	4
Банксүлжээ систем .....	4
Бага дүнтэй төлбөр тооцооны систем .....	4
Картын нэгдсэн сүлжээ.....	4
Төлбөрийн хэрэгсэл.....	5
3. Монголбанкнаас хяналтын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ.....	5
Төлбөрийн системийн хяналтын хууль эрх зүйн зохицуулалт .....	6
Төлбөрийн системийн хяналтын үйл ажиллагаа .....	6
1. Шаардлагатай мэдээлэл олж авах .....	6
2. Хяналт тавих.....	6
3. Үнэлгээ хийх .....	8
4. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх .....	8
5. Шаардлагатай өөрчлөлт хийх .....	9

## **ТОВЧ ХУРААНГУЙ**

---

“Үндэсний төлбөрийн системийн хяналтын тайлан” нь Монголбанкнаас хэрэгжүүлж буй төлбөрийн системийн хяналттай холбоотой үйл ажиллагааг нийтэд ил тод болгох зорилгоор жил тутам гарах тайлан юм. Энэхүү тайлан нь төлбөр тооцооны системийн оператор болон төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид, дотоодын болон олон улсын зохицуулагч байгууллагууд, хэрэглэгчдэд Монголбанкнаас төлбөрийн системд тавих хяналтын ач холбогдол, зорилгыг ойлгуулах боломж бүрдэх юм.

Тайлан нь дараах 3 бүлэгтэй.

1. Төлбөрийн системийн хяналтын талаарх олон улсын зарчмууд;
2. Монголбанкнаас тавих хяналтын хамрах хүрээ;
3. Монголбанкнаас хяналтын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ.

## 1. ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ХЯНАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ЗАРЧМУУД

---

### *Төлбөрийн систем гэж юу вэ?*

Төлбөрийн систем нь төлбөр гүйцэтгэгч, хүлээн авагчийн хооронд мөнгөн хөрөнгө шилжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа, түүнийг гүйцэтгэх, үр дүнгийн тооцооллыг хийх эрх бүхий байгууллага, холбогдох дүрэм, журам, гэрээ болон төлбөрийн хэрэгслийн цогц нэгдэл юм.

Төлбөр, мөнгөн гуйвуулга, үнэт цаасны клиринг, төлбөр тооцооны системүүд нийт эдийн засагт, ялангуяа санхүүгийн систем болон мөнгөний бодлогын хэвийн үйл ажиллагаанд нэн чухал үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр системийн үр ашигтай, хэвийн ажиллагаа нь байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн, бизнес эрхлэгчдэд санхүүгийн үүргээ биелүүлэх, мөнгөн хөрөнгөө аюулгүй шилжүүлэх боломж олгодог.

### *Төлбөрийн системийн эрсдэл*

Олон улсын төлбөр тооцооны банкнаас төлбөрийн системд зээлийн, системийн, хууль эрх зүйн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, төлбөр тооцооны, үйл ажиллагааны, бизнесийн эрсдэл үүсэж болно гэж тодорхойлсон байна.

Зөв зохион байгуулж, удирдаж чадсан төлбөрийн болон төлбөр тооцооны систем нь санхүүгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн өсөлтийг дэмжих сайн талтай. Үр ашигтай, аюулгүй, найдвартай ажиллагаатай төлбөрийн системийн тусламжтайгаар бараа, үйлчилгээний зардлыг бууруулж, санхүүгийн зах зээл, арилжааны гүйлгээ, хөрөнгө оруулалт болон эдийн засгийн бусад үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах боломж бүрддэг. Харин эдгээр системүүдийн үйл ажиллагааны доголдол нь санхүүгийн зах зээл дээр хүндрэл үүсгэх, ялангуяа зах зээлийн хямралын үед хямралыг даамжруулах эх үүсвэр болдог. Төлбөр тооцооны үр ашиггүй байдлаас шалтгаалж хэрэглэгчийн зардал өсөж, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд саад учирдаг. Илүү өргөн хүрээнд авч үзвэл дээр дурдсан асуудлууд нь санхүүгийн систем болон үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх олон нийтийн итгэлд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Төлбөр тооцооны системд төлбөрийн, клирингийн, зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, хууль эрх зүйн, үйл ажиллагааны, системийн эрсдэл зэрэг эрсдэл үүсдэг. Системийн хэмжээнд гүйлгээний тоо болон дүн хурдацтай өсөхийн хэрээр төлбөрийн системийн эрсдэлийн хэмжээ ихэснэ. Өндөр түвшний технологи нэвтрэхтэй зэрэгцэн шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгслүүд болон төлбөр төлөх арга нэмэгдэж, төлбөрийн системийг нийтэд нь нарийн төвөгтэй, олон талт болгож байна. Мөн сүүлийн жилүүдэд хувийн хэвшлийн зүгээс төлбөрийн үйлчилгээ үзүүлэх нь хурдацтай өргөжиж, банк бус эсвэл санхүүгийн бус байгууллага тус зах зээлд хүч түрэн орж байна. Энэ хандлага нь нарийн төвөгтэй нөхцөл байдлыг үүсгэж, эрсдэлийг нэмэгдүүлж байгаа учраас төлбөр тооцооны болон клирингийн дэд бүтэц, төлбөрийн зохицуулалтыг бүхэлд нь хамарсан цогц хяналтыг хэрэгжүүлэх шаардлага бий болоод байна.

### ***Төлбөрийн системийн хяналт гэж юу вэ?***

Төлбөрийн системийн хяналт нь төлбөр тооцооны системд хяналт тавих, үнэлгээ хийх, шаардлагатай үед өөрчлөлт оруулах замаар төлбөрийн системийн найдвартай, үр ашигтай ажиллагааг хангуулсны үр дүнд үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх зорилготой Төв банкны үүрэг юм.

Төлбөрийн системийн хяналтын зорилго нь төлбөр тооцооны зохицуулалт системийн эрсдэлийг хязгаарлан, хэрэглэгч болон эдийн засгийн хэрэгцээг хангаж, найдвартай, үр ашигтай ажиллаж байгааг баталгаажуулах явдал юм. Энэ нь тодорхой системийг түүнд тогтоосон стандарт болон хяналтын бодлогын шаардлагын дагуу үнэлэхээс гадна эдийн засаг дахь төлбөр тооцооны зохицуулалтыг бүхэлд нь ойлгоход чиглэсэн маш өргөн үйл ажиллагааг хамардаг.

Төлбөрийн системийн хяналтын үүрэг нь банкны хяналт шалгалтаас ялгаатай ойлголт юм. Банкны хяналт шалгалтын нэгж нь санхүүгийн байгууллага нэг бүрийг зохицуулж, шалгадаг бол төлбөрийн системийн хяналт нь систем, түүний оролцогч, төлбөрийн хэрэгслийг бүхэлд нь өргөн хүрээнд авч үздэг байна.

### ***Төлбөрийн системийн хяналтын зарчмууд***

Төв банкны төлбөрийн системийн хяналтын чиг үүрэг нь Олон улсын төлбөр тооцооны банкны Төлбөрийн болон зах зээлийн дэд бүтцийн хороо (ТЗЗДБХ)-оос олон улсын хэмжээнд боловсруулан гаргасан тодорхой зарчмуудад тулгуурладаг. Тус хорооноос 2005 онд гаргасан “Төв банкны хяналтын тайлан”-д<sup>1</sup> дотоодын болон олон улсын хэмжээнд төлбөр тооцооны системүүдэд үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлэх үндсэн 5 зарчмыг тодорхойлсон.

1. Төв банк нь өөрийн хяналтын бодлогоо олон нийтэд мэдээлэх ёстой ба ингэхдээ систем бүрт тавигдах бодлогын шаардлага эсвэл стандартууд мөн аль системд хамаарахыг тогтоох шалгуурууд зэргийг оруулна.
2. Төв банк нь төлбөр тооцооны системүүдэд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн холбогдох стандартыг мөрдүүлэх ёстой.
3. Төв банк нь хяналтын үүрэг хариуцлагаа үр дүнтэй хэрэгжүүлэх бүрэн эрх, чадавхтай байх ёстой.
4. Төв банкны ажиллуулдаг системүүд, адилтгах төлбөрийн болон төлбөр тооцооны системүүдэд хяналтын стандартуудыг тогтмол мөрдүүлэх ёстой.
5. Төлбөрийн болон төлбөр тооцооны системүүдийн аюулгүй, үр ашигтай байдлыг дэмжихийн тулд төв банк нь бусад төв банкууд болон эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах ёстой.

Дээрх “Төв банкны хяналтын тайлан”-аас гадна ТЗЗДБХ болон Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (ҮЦХОУБ)-аас хамтран гаргасан “Санхүүгийн зах зээлийн дэд

<sup>1</sup> <https://www.bis.org/cpmi/publ/d68.pdf>

бүтэц (СЗЗДБ)-ийн зарчим”-д <sup>2</sup> СЗЗДБ-ийн хяналт, зохицуулалт, шалгалттай холбоотойгоор эрх бүхий байгууллагын хүлээх 5 үүрэг хариуцлагыг тодорхойлсон байдаг.

## **2. МОНГОЛБАНКНААС ТАВИХ ХЯНАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭ**

---

Үндэсний төлбөрийн систем (ҮТС)-ийн найдвартай, үр ашигтай байдлыг хангах Монголбанкны бүрэн эрхийн үндсэн дээр төлбөрийн системийн хяналтын хамрах хүрээ тодорхойлогдоно. Монголбанк нь дараах төлбөрийн систем болон төлбөрийн хэрэгсэлд хяналт тавих үүргийг хүлээдэг.

### ***Банксүлжээ систем***

Монголбанкны Төлбөрийн бодлого, зохицуулалтын хэлтэс (ТБЗХ)-ийн хариуцан ажиллуулж буй их дүнтэй төлбөр тооцооны Банксүлжээ (RTGS) систем нь Монгол Улсын үндэсний төлбөрийн системийн суурь юм. Энэ систем нь 17 банк, Банкны эрх хүлээн авагч 2, Хөгжлийн банк, Сангийн яамны Төрийн сангийн газар, Арилжааны төлбөр тооцоо ТӨХХК, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ТӨХХК-ийн харилцах дансыг Монголбанкинд байршуулж, эдгээр системийн оролцогч хооронд хийгдэж буй их дүнтэй төлбөр нэг бүрийг бодит цагийн горимоор гүйцэтгэхээс гадна ҮЦГТ-өөр тухайн өдөрт дамжсан банк хоорондын бага дүнтэй болон картын гүйлгээний үр дүнгийн төлбөр тооцооллыг дараагийн өдөрт нь холбогдох дансанд хийж байна. Дэлхий нийтээр RTGS системийг системийн хувьд нэн чухал систем гэж тооцож, Төв банкны эзэмшилд байлгадаг.

Банксүлжээ системийн үйл ажиллагааг МБЕ-ийн 2013 оны А-51 тоот тушаалаар батлагдсан “Төлбөрийн системийн оролцогч хоорондын их дүнтэй төлбөр тооцооны журам”-аар<sup>3</sup> зохицуулна.

### ***Бага дүнтэй төлбөр тооцооны систем***

Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төв (ҮЦГТ)-ийн хариуцан ажиллуулдаг бага дүнтэй төлбөр тооцооны систем нь банк хоорондын цахим кредит шилжүүлгийн систем юм. Энэ нь 1,000,000.01 хүртэлх төгрөгийн бага дүнтэй гүйлгээг боловсруулдаг бөгөөд олон улсад жижиглэнгийн төлбөрүүдэд зориулсан системийн нэг төрөл гэж үздэг. Уг системийн оролцогчид нь банкууд, Хөгжлийн банк, Сангийн яамны Төрийн сангийн газар, Арилжааны төлбөр тооцоо ТӨХХК, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ТӨХХК байна.

Энэхүү системийн үйл ажиллагааг МБЕ-ийн 2016 оны А-145 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан “Төлбөрийн системийн оролцогч хоорондын бага дүнтэй төлбөр тооцооны журам”-аар<sup>4</sup> зохицуулна.

### ***Картын нэгдсэн сүлжээ***

Банк хоорондын картын нэгдсэн сүлжээ нь АТМ-аас бэлэн мөнгө авах, шилжүүлэг хийх, ПОС терминал дээр бараа үйлчилгээний төлбөр төлөх, цахим худалдан авалт зэрэг

---

<sup>2</sup> <http://www.bis.org/cpmi/publ/d101a.pdf>

<sup>3</sup> <https://mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/ihduntei.pdf>

<sup>4</sup> <https://mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/bagaduntei.pdf>

төлбөрийн картаар хийх гүйлгээг боловсруулах жижиглэнгийн төлбөрүүдэд зориулсан систем юм. Картын нэгдсэн сүлжээг ҮЦГТ хариуцан ажиллуулж, тухайн өдөрт төлбөрийн системийн оролцогч хооронд дамжсан гүйлгээнүүдийн үр дүнгийн тооцоолол буюу цэвэршүүлсэн дүнг Банксүлжээ системд дамжуулснаар төлбөр тооцоо хийгддэг. Картын нэгдсэн сүлжээний шууд оролцогчид нь Худалдаа хөгжлийн банк (ХХБ), ХААН банк, Голомт банк, Төрийн банк, Капитал банк, Хас банк бөгөөд бусад банкууд дэд гишүүнээр холбогдон, ХХБ-ны свитчийн сүлжээгээр өөрийн картын гүйлгээг дамжуулж, картын нэгдсэн сүлжээнд оролцож байна.

Свитч нь “Төлбөрийн картын журам”-д заасны дагуу карт гаргагч болон карт хүлээн авагчийн хооронд картын төлбөр тооцоог дамжуулах, үр дүнгийн тооцоолол боловсруулах үйл ажиллагааны зөвшөөрлийг Монголбанкнаас авдаг. Одоогийн байдлаар ХХБ свитчийн зөвшөөрөл авч, өөрийн сүлжээнд 5 дэд гишүүн банктайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Картын нэгдсэн сүлжээний үйл ажиллагааг МБЕ-ийн 2016 оны А-160 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан “Төлбөрийн картын журам”-аар<sup>5</sup> зохицуулна.

### ***Төлбөрийн хэрэгсэл***

Төв банк нь шинэлэг төлбөрийн хэрэгсэл болон хандалтын сувгуудын найдвартай, үр ашигтай байдал, хэрэглэгчийн мөнгөн хөрөнгийг хамгаалах тал дээр анхаардаг тул цахим мөнгө, төлбөрийн карт, хөдөлгөөнт төлбөр тооцоо гэх мэт шинэлэг төлбөрийн хэрэгслүүдийг өөрийн хяналтад оруулдаг.

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 8.2-д заасны дагуу төгрөгийг орлох төлбөрийн хэрэгслийн зөвшөөрлийг Монголбанк олгодог. Одоогоор Монголбанкны зөвшөөрөлтэй төгрөгийг орлох төлбөрийн хэрэгсэл нь зөвхөн төлбөрийн карт байна. Банкууд төлбөрийн карт гаргах, хүлээн авах үйл ажиллагаа эрхлэхэд “Төлбөрийн картын журам”-ын<sup>6</sup> дагуу шаардлагатай материалыг бүрдүүлэн Монголбанкинд ирүүлж байна. ТБЗХ ирүүлсэн журам, заавар, гэрээ, бусад баримт бичгийг дүгнэж, шаардлага хангасан нөхцөлд картын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгож байна. Үүнтэй холбоотойгоор 2016 онд 6 банкны төлбөрийн картын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгасан байна<sup>7</sup>. Монголбанкнаас олгосон төлбөрийн картын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1-т харууллаа.

## **3. МОНГОЛБАНКНААС ХЯНАЛТЫН ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ**

Монголбанкнаас хэрэгжүүлж буй төлбөрийн системийн хяналтын үүрэг нь төлбөр тооцооны системүүдийг болон төлбөрийн зохицуулалтыг үүсэж болзошгүй эрсдэлээс хангалттай хэмжээнд хамгаалж байгааг, түүнчлэн системийн бүтэц, тухайн системийг Төв банк эсвэл хувийн хэвшил хариуцан ажиллуулж байгаа эсэхээс үл хамааран үр ашигтай ажиллаж байгааг баталгаажуулах явдал юм.

<sup>5</sup> [https://mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/kartiin\\_juram2.pdf](https://mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/kartiin_juram2.pdf)

<sup>6</sup> [https://mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/kartiin\\_juram2.pdf](https://mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/kartiin_juram2.pdf)

<sup>7</sup> <https://mongolbank.mn/documents/mirror/2016/paymentsystemz.pdf>

### ***Төлбөрийн системийн хяналтын хууль эрх зүйн зохицуулалт***

Олон улсын стандартад Төв банкыг хяналтын зорилгод нийцүүлэн хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэх хууль ёсны онцгой эрхтэй, хүчин чадалтай байхыг шаарддаг. Төв банк (Монголбанк)-ны тухай хуулинд Монголбанк нь банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах үүрэг хүлээж, энэ үйл ажиллагааг зохицуулсан журам гаргахаар заасан байдаг.

Монголбанкинд Дэлхийн банкнаас “Төлбөрийн системийн хууль эрх зүйн орчныг сайжруулах, хяналтын чадавхыг бэхжүүлэх” зорилгоор техник туслалцаа үзүүлж байгаа бөгөөд энэхүү техник туслалцааны дэмжлэгтэйгээр “Үндэсний төлбөрийн системийн тухай” хуулийн төслийг боловсруулан, УИХ-д өргөн барихаар ажиллаж байна. Уг “Үндэсний төлбөрийн системийн тухай” хуулийн төсөлд Монголбанк нь ҮТС-ийг бүхэлд нь болон бүрэлдэхүүн хэсгүүдийг зохицуулах, хянах талаар тусгаж, ҮТС-д хяналт тавих үүргийг Монголбанкинд хүлээлгэсэн байна.

Монголбанкнаас төлбөрийн системийн хяналтыг хэрэгжүүлэхдээ Монголбанкны Ерөнхийлөгчийн А-265 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Төлбөрийн системийн хяналтын бодлого”-ыг<sup>8</sup> удирдлага болгон ажиллаж байна.

Монголбанк нь өөрийн хяналтын үйл ажиллагаатай холбоотой журмуудыг гаргаж, мөрдөн ажилладаг. Тухайлбал МБЕ-ийн 2015 оны А-76 тушаалаар батлагдсан “Төлбөрийн системийн оролцогчдын үйл ажиллагаанд газар дээр нь шалгалт хийх журам”-ыг<sup>9</sup> ТБЗХ-ийн хянан шалгагчид үйл ажиллагаандаа мөрдөж байна.

### ***Төлбөрийн системийн хяналтын үйл ажиллагаа***

Монголбанк төлбөрийн системийн хяналтыг хэрэгжүүлэхдээ дараах үндсэн 5 үйл ажиллагааг явуулж, төрөл бүрийн хяналтын хэрэгслийг ашиглаж байна.

#### **1. Шаардлагатай мэдээлэл олж авах**

ТБЗХ-ийн хянан шалгагч нар нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн дагуу төлбөрийн системийн оролцогчдоос шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь гаргуулан авах бүрэн эрхтэй байдаг. Холбогдох журмуудад заасны дагуу оролцогчид гүйлгээний тоон мэдээллийг тогтмол ирүүлдэг. Үүний дагуу улирал тутам төлбөрийн системийн тайланг Монголбанкны цахим хуудсанд<sup>10</sup> нийтэд ил тод болгодог. Хяналтанд хамрагдаж байгаа төлбөр тооцооны системүүд 7 хоног тутам тухайн системээр дамжсан амжилттай болон амжилтгүй гүйлгээний мэдээлэл, тасралтгүй найдвартай ажиллагааны үзүүлэлт зэргийг багтаасан үйл ажиллагааны тайлан гаргаж, ТБЗХ-т ирүүлж байна. Энэ үйл ажиллагааны тайланг сар тутам нэгтгэн, Монголбанкны удирдлагад танилцуулж, мэдээллээр хангаж байна.

#### **2. Хяналт тавих**

ТБЗХ нь оператор болон оролцогчийн эрх зүйн баримт, мэдээлэл, статистик үзүүлэлтүүдийг тодорхой давтамжтайгаар цуглуулж, дүрэм, журамд нийцэж байгаа эсэхэд

<sup>8</sup> <https://mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/2016/20160928.pdf>

<sup>9</sup> [https://mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/2015/20150428\\_A76.pdf](https://mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/2015/20150428_A76.pdf)

<sup>10</sup> <https://mongolbank.mn/liststatistic.aspx?id=15>



хяналт тавин ажиллаж байна. Газар дээр нь хийсэн шалгалтын үр дүнг системийн найдвартай, үр ашигтай байдлын үнэлгээнд ашиглаж болдог. Газар дээр нь хийх шалгалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан төлөвлөгөөний дагуу хийж байна. 2016 онд төлбөрийн системийн оролцогч бүх банкуудад иж бүрэн шалгалтыг хийж гүйцэтгэсэн ба шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрт мэдэгдэж, залруулах талаар хянан шалгагч нар өөрийн бүрэн эрхийн хүрээнд арга хэмжээ авч ажиллалаа.


Банкуудаас системийн хэмжээний тайланг гаргуулан авч, мониторинг хийх бөгөөд тоон мэдээнд үндэслэн хяналт шинжилгээ хийж байна. Улирал тутам гаргаж буй төлбөрийн системийн тайлан, мэдээг Монголбанкны цахим хаягаас <sup>11</sup> авах боломжтой. Дараах хүснэгтэд 2013-2015 онд их болон бага дүнтэй төлбөр тооцооны систем, картын нэгдсэн сүлжээгээр дамжсан гүйлгээний тоо ба дүнг харуулав.

Хүснэгт 1 (мянган ширхэг, их наяд төгрөг)

Систем	2013		2014		2015	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Их дүнтэй	1 100.8	55.0	1 379.1	63.5	1 419.2	57.9
Бага дүнтэй	16 714.3	0.9	18 475.4	1.1	20 794.8	1.8
Картын нэгдсэн сүлжээ	23 586.6	1.2	31 761.7	1.7	44 553.8	2.2

Төлбөрийн бодлого зохицуулалтын хэлтэс нь төлбөрийн системийн оператор болон оролцогчдын тасралтгүй найдвартай ажиллагаанд тогтмол хяналт тавин ажиллаж байна. 2016 оны 4 дүгээр сард Банксүлжээ системд 100 минутын тасралт үүссэн байна. Үүний гол шалтгаан нь хариуцсан ажилтны буруутай үйл ажиллагаа байсан. Бага дүнтэй төлбөр тооцооны системд нийт 192 минутын, картын нэгдсэн сүлжээнд 17 минутын, ХХБ-ны свитчийн сүлжээнд 63 минутын тасралтууд тус тус үүсжээ. Эдгээр тасралтуудын гол шалтгаан нь техник болон програм хангамж, өгөгдлийн сангийн алдаа байсан байна.

График 1



<sup>11</sup> <https://mongolbank.mn/liststatistic.aspx?id=15>

### 3. Үнэлгээ хийх

СЗЗДБ-ийг үнэлэх “Үнэлгээний аргачлал”-ыг 2015 оны МБЕ-ийн А-98 тоот тушаалаар баталсан<sup>12</sup> бөгөөд уг аргачлалын дагуу жил бүр системийн хувьд нэн чухал төлбөрийн системд үнэлгээ хийдэг. Энэхүү үнэлгээг хийснээр төлбөрийн системд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлон, түүнийг үнэлэх, бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломж бүрдэж байна.

Монголбанк нь тухайн системээр боловсруулж буй гүйлгээний дундаж дүн, гүйлгээний төрөл, хэрэглэгчийн тоог харгалзан үзсэний үндсэн дээр төлбөрийн системийг системийн хувьд нэн чухал эсэхийг шийддэг. Одоогийн байдлаар энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу Их дүнтэй төлбөр тооцооны Банксүлжээ системийг системийн хувьд нэн чухал гэж үзэж байна.

"СЗЗДБ-ийн зарчмууд"-д дурдсанаар дэд бүтэц нь оролцогчид, холбогдох эрх бүхий байгууллагууд болон олон нийтийг шаардлагатай мэдээллээр хангаж, тухайн улс орны хууль эрх зүйн орчинд нийцүүлэн дэд бүтцүүд нь зарчмуудын хэрэгжилтийг, холбогдох эрх бүхий байгууллагууд нь үүрэг хариуцлагын биелэлтийг хангах шаардлагатай. Мөн удирдлагын үүрэг хариуцлагын үнэлгээний гол зорилго нь эрх бүхий байгууллагууд дэд бүтцийн хяналт шалгалт, зохицуулалттай холбоотой үүрэг хариуцлагаа биелүүлж буй эсэх, хэр сайн хэрэгжүүлж байгааг тодорхойлж, биелэлтийг дэмжихэд оршино.

ОУТГБ-аас гаргасан Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн 24 зарчим, 5 үүрэг хариуцлагын хэрэгжилт их дүнтэй төлбөр тооцооны системийн түвшинд хэрхэн хангагдаж байгааг тодорхойлж, хэрэгжилтийн түвшинг ахиулж, тогтмол хангуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 2016 онд “Банксүлжээ системийн үнэлгээ”-г хийсэн бөгөөд үнэлгээний үр дүнгээс харахад дэд бүтцийн 24 зарчмын 9 зарчим хэрэгжсэн, 6 зарчим ерөнхийдөө хэрэгжсэн, 2 зарчим хэсэгчлэн хэрэгжсэн, хэрэгжээгүй зарчим байхгүй, 7 зарчим хамааралгүй байна. 5 үүрэг хариуцлагын үүрэг хариуцлага А ерөнхийдөө хэрэгжсэн, Б хэсэгчлэн хэрэгжсэн, В болон Г хэрэгжсэн, Д хамааралгүй байна. "Хэрэгжсэн" гэж үнэлээгүй зарчмуудын хувьд анхаарвал зохих асуудлыг шийдвэрлэж, хэрэгжилтийн түвшинг ахиулах талаар системийн операторт зөвлөмж өгсөн байна.

Түүнчлэн “Төлбөрийн системийн хяналтын бодлого”-д заасны дагуу Монголбанкны хариуцан ажиллуулж буй Төв банкны үнэт цаасны системд анх удаа үнэлгээ хийсэн бөгөөд цаашид уг үнэлгээг сайжруулахаар ажиллаж байна.

### 4. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх

Монголбанк санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд төлбөрийн системийн эрсдэлийг тодорхойлж, үнэлж, бууруулах арга хэмжээ авч байх шаардлагатай. Энэ нь санхүүгийн зах зээл, цаашлаад эдийн засгийг бүхэлд нь хамарч болох үр дагавартай учраас системийн эрсдэлийг төлбөрийн системийн хяналтын үндсэн асуудал болгон тавьдаг. Иймээс хяналтын тогтолцоог сайтар зохион байгуулснаар төлбөрийн системийн эрсдэлийг бууруулах ач холбогдолтой юм. Төлбөрийн системд учирч болзошгүй эрсдэлүүдийг “Төлбөрийн системийн хяналтын бодлого”-д тодорхойлсон бөгөөд эдгээр эрсдэлийг удирдахтай холбоотой журам гаргахаар ажиллаж байна.

<sup>12</sup> <https://mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/2015/20150706.pdf>

**5. Шаардлагатай өөрчлөлт хийх**

Үнэлгээний үр дүнг үндэслэн тухайн системийн найдвартай, үр ашигтай байдлын түвшинг хангаж байгаа эсэх тухай дүгнэлт гаргаж, тухайн системд шаардлагатай өөрчлөлтийг хийлгэх арга хэмжээ авдаг. Банксүлжээ системд 2016 онд хийсэн үнэлгээний үр дүнд үндэслэн 2017 оны ажлын төлөвлөгөөнд хийгдэх шаардлагатай ажлуудыг тусгасан.

**ХАВСРАЛТ 1**

Д/д	Зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Карт гаргах зөвшөөрөл	Карт хүлээн авах зөвшөөрөл	Зөвшөөрөл олгосон хугацаа	Зөвшөөрөл дуусах хугацаа
1	Капитал банк <a href="https://capitalbank.mn">https://capitalbank.mn</a>	₮ карт, Visa, UnionPay	₮ карт, Visa, UnionPay	2010.09.17	2019.09.17
2	Худалдаа хөгжлийн банк (Свичийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан - 2018.08.10) <a href="http://www.tdbm.mn/mn/">http://www.tdbm.mn/mn/</a>	₮ карт, Visa, Mastercard, UnionPay	₮ карт, Visa, Mastercard, UnionPay, JCB, Diners Club, Discover	2010.06.25	2019.06.25
3	Хаан банк <a href="https://www.khanbank.com/">https://www.khanbank.com/</a>	₮ карт, Visa, Mastercard, UnionPay	₮ карт, Visa, Mastercard, UnionPay, JCB	2011.12.30	2019.06.30
4	Голомт банк <a href="http://www.golomtbank.com/">http://www.golomtbank.com/</a>	₮ карт, AMEX, Visa, Mastercard, UnionPay	₮ карт, Visa, Mastercard, UnionPay, AMEX, JCB	2009.12.31	2019.07.01
5	Ариг банк <a href="https://www.arigbank.mn">https://www.arigbank.mn</a>	₮ карт, Visa	₮ карт, Visa, UnionPay, JCB, дотоодын Mastercard	2012.12.05	2018.12.05
6	Улаанбаатар хотын банк	₮ карт,	₮ карт,	2010.12.29	2016.12.29

	<a href="http://www.ubcbank.mn/index.php">http://www.ubcbank.mn/index.php</a>	Visa	Visa, UnionPay, JCB Дотоодын Mastercard		
7	Үндэсний хөрөнгө оруулалтын банк <a href="http://www.nibank.mn">http://www.nibank.mn</a>	₮ карт, Visa	₮ карт, UnionPay, Visa, Дотоодын Mastercard, JCB	2013.01.08	2019.01.08
8	Капитрон банк <a href="http://www.capitronbank.mn/">http://www.capitronbank.mn/</a>	₮ карт, Visa, Mastercard	₮ карт, Visa, Mastercard, UnionPay	2012.09.26	2018.09.26
9	Хас банк <a href="http://www.xacbank.mn/">http://www.xacbank.mn/</a>	₮ карт, Visa, UnionPay	₮ карт, Visa, UnionPay, Mastercard, JCB, Золотая Корона	2011.07.29	2017.08.01
10	Чингис хаан банк <a href="http://www.ckbank.mn/">http://www.ckbank.mn/</a>	₮ карт	₮ карт, Дотоодын Mastercard, Дотоодын Visa, Дотоодын UnionPay	2013.04.30	2019.04.30
11	Төрийн банк <a href="https://www.statebank.mn/w/mn/">https://www.statebank.mn/w/mn/</a>	₮ карт, Visa, UnionPay, JCB	₮ карт, Visa, UnionPay, JCB, Дотоодын Mastercard	2014.03.18	2017.03.18

12	Богд банк <a href="http://www.bogdbank.com/">http://www.bogdbank.com/</a>	₮ карт	₮ карт	2016.09.21	2019.09.21
----	--	--------	--------	------------	------------